



**ГАДААДЫН ИРГЭН, ХАРЬЯАТЫН  
АСУУДАЛ ЭРХЛЭХ ГАЗРЫН ДАРГЫН  
ТУШААЛ**

2012 оны 02 сарын 28 өдөр


Дугаар 1/93

Улаанбаатар хот

Г  
Загвар батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 52 дугаар тушаалаар баталсан «Барьцаа гаргуулах, буцаан олгох, барьцааны хэмжээг тогтоох журам»-ын 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. «Барьцааны гэрээ»-ний загварыг нэгдүгээр, «Мөнгөн хөрөнгийг барьцаалсан болон буцаан олгосон, шилжүүлсэн тухай баримт»-ын загварыг хоёрдугаар хавсралт ёсоор тус тус баталсугай.
2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналтын хэлтсийн дарга (Л.Батсүх), Санхүү, аж ахуйн албаны дарга бөгөөд ерөнхий нягтлан бодогч (Л.Бямбадорж) нарт тус тус үүрэг болгосугай.



Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх  
газрын даргын 2012 оны 36 дугаар  
тушаалтын нэгдүгээр хавсралт

## БАРЬЦААНЫ ГЭРЭЭ

20..... оны ..... сарын ..... өдөр

№

(баримт үйлдсэн газрын нэр)

Нэг талаас барьцааг тусгай дансанд байршуулсан \_\_\_\_\_ овогтой

(эцэг, эхийн нэр)

гадаадын иргэн, түүнийг уригч болон бусад этгээд /цаашид  
(өөрийн нэр)

“барьцаалуулагч” гэх/, нөгөө талаас Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрыг төлөөлж,

\_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_ тухайн зөрчлийг шалгаж буй хяналтын  
(эцэг, эхийн нэр) (өөрийн нэр)

улсынбайцаагч /цаашид “барьцаалагч” гэх/ нар харилцан тохиролцож, энэхүү гэрээг байгуулав.

### Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү гэрээгээр гадаадын иргэн, уригч болон бусад этгээдээс гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36.1.1, 36.1.3-т заасан үндэслэлээр saatuuulagdsan, эсхүл saatuuulagdaх гэж байгаа гадаадын иргэнд холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлэх хүртэл түүнийг saatuuulahgүй байх, оргон зайлсан тохиолдолд түүнийг эрэн сурвалжлах, захиргааны зөрчлийг арилгах, харьяалах улс руу нь буцаах зардалд зарцуулах мөнгөн хөрөнгө буюу барьцаа түүний хэмжээг тогтоох, барьцаа гаргах, барьцааг буцаан олгох, олгохоос татгалзах тухай асуудлыг зохицуулна.

1.2. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1.1 36.1.3-т заасан зөрчил гаргасан \_\_\_\_\_ Улсын иргэн \_\_\_\_\_ овогтой

(эцэг, эхийн нэр)

/г барьцаатайгаар saatuuulahgүйгээр ГИХАЭГ-аас дуудсан цагт

(өөрийн нэр)

саадгүй ирүүлэх, /ирэх/ болон энэ гэрээнд заасан бусад үүргийг хүлээв.

1.3. Барьцааны хэмжээг Хууль зүй, дотоод хэргийн сайдын 2011 оны 52 дугаар тогтоолоор батлагдсан “Барьцаа гаргах, буцаан олгох, барьцааны хэмжээ тогтоох журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.1, 4.1.2, 4.1.3-т заасны дагуу тогтооно.

1.4. Энэхүү гэрээний барьцааны зүйл нь Монгол Улсын мөнгөн тэмдэгт болох төгрөг байна.

1.5. Барьцаалуулагч гэрээний зүйл болох \_\_\_\_\_  
 (тоогоор)(мөнгөн дүн үсгээр)

төгрөгийн мөнгөн хөрөнгийг барьцаалж байна.

1.6. Паспорт, түүнийг орлох баримт бичиггүй, эсхүл хэн болох нь тогтоогдохгүй байгаа гадаадын иргэнээс барьцаа гаргуулах тохиолдолд Монгол Улсад оршин суух хаягтай, тодорхой ажил, хөдөлмөр эрхэлдэг, хөрөнгийн эх үүсвэртэй, батлан даагчийн үүргийг бүрэн хүлээх чадвартай, насанд хүрсэн 2-оос доошгүй батлан даагчаар дамжуулан барьцааны гэрээг хийнэ.

### **Хоёр. Барьцааны зүйлийн талаар талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг**

#### **2.1. Барьцаалагчийн эрх, үүрэг**

2.1.1. Барьцааны зүйлийн хэмжээг энэхүү гэрээний 1.3-т заасны дагуу үнэн зөв тодорхойлох;

2.1.2. Барьцаалуулагчид барьцааны гэрээний зүйл болох барьцааны мөнгөн хөрөнгийг тусгай дансанд байршуулах, Монгол Улсын мөнгөн тэмдэгтээр тушаах талаар зааварчилгаа өгөх;

2.1.3. Барьцааны гэрээний нэг хувийг зөрчлийн материалд хавсаргах, нэг хувийг барьцаалуулагчид өгөх;

2.1.4. Барьцаалуулагчаас тухайн зөрчил гаргасан гадаадын иргэний талаар мэдээлэл авах;

2.1.5. Барьцаалуулагчаас гэрээнд заасан үүргээ биелүүлэхийг шаардах;

2.1.6. Барьцаалуулагч хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд барьцааг буцаан олгох;

2.1.7. Барьцааг буцаан олгоходо барьцаалуулагчийн дансанд шилжүүлж, холбогдох санхүүгийн баримтыг өгөх, энэ тухай барьцааны гэрээнд тэмдэглэл үйлдэн санхүүгийн бүртгэлээс хасуулах, зөрчлийг шалгасан материалд хавсаргах;

2.1.8. Барьцаалуулагч хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу барьцаатайгаар saatuuulagdaagүй иргэн оргон зайлсан, барьцаалуулагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барьцааны гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, барьцаатайгаар saatuuulagdaagүй гадаадын иргэн дахин зөрчил гаргасан тохиолдолд уг гадаадын иргэнийг saatuuulaх, эрэн сурвалжлах, холбогдох бусад арга хэмжээнд шаардагдах зардлыг барьцааны мөнгөн хөрөнгөөс захиран зарцуулах арга хэмжээ нэн даруй авах;

#### **2.2. Барьцаалуулагчийн эрх, үүрэг**

2.2.1. Барьцаалагчаас барьцааны гэрээний агуулгыг тайлбарлахыг шаардах;

2.2.2. Барьцааны мөнгөн хөрөнгийг тусгай дансанд тушаах, түүнийг буцааж авах тухай шаардлагатай мэдээллийг лавлах;

2.2.3. Барьцааны гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлсэн тохиолдолд барьцааг буцаан авах талаар шаардах;

2.2.4. Хяналтын улсын байцаагчийн тавьсан шаардлагыг биелүүлэх;

2.2.5. Барьцаатайгаар саатуулагдаагүй гадаадын иргэнд холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлүүлэх;

2.2.6. Барьцаатайгаар саатуулагдаагүй иргэн оргон зайлсан тохиолдолд энэ тухай Гадаадын иргэн, харьяатын асуудал эрхлэх газрын холбогдох хяналтын улсын байцаагчид нэн даруй мэдэгдэх;

2.2.7. Барьцаатайгаар саатуулагдаагүй гадаадын иргэн дахин зөрчил гаргахгүй байх талаар хяналт тавих;

2.2.8. Тухайн зөрчлийг шалгаж байгаа хяналтын улсын байцаагчид үнэн зөв мэдээлэл өгөх;

#### **Гурав. Барьцаалагчийн шаардлагыг хангах**

3.1. Шаардах эрх үүссэн буюу үүргийн гүйцэтгэлийг хангах нөхцөл байдал бий болсон тохиолдолд барьцааны зүйл болох мөнгөн хөрөнгийг захиран зарцуулах замаар үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэмжээ авна.

3.2. Барьцаатайгаар саатуулагдаагүй иргэн оргон зайлсан, барьцаалуулагч хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр барьцааны гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй, барьцаатайгаар саатуулагдаагүй гадаадын иргэн дахин зөрчил гаргасан бол барьцааны зүйлээс дээрх зөрчлийг арилгахад шаардагдах зардал болон зохих төлбөрийг гарган үүргийн гүйцэтгэлийг хангах арга хэмжээ авна.

3.3. Барьцаалуулагчийн барьцааны зүйлээс шаардагдах зардал болон зохих төлбөрийг гаргуулж, холбогдох асуудлыг эцэслэн шийдвэрлэнээр барьцаалагчийн шаардлагыг хангасан гэж үзнэ.

*Нэмэлт нөхцөл:*

---



---



---

#### **Дөрөв. Барьцааны эрх дуусгавар болох**

4. Дараах тохиолдолд барьцааны эрх дуусгавар болно:

- 4.1. Барьцаагаар хангагдах шаардлага дуусгавар болсон;
- 4.2. Барьцааны зүйлийг барьцаалуулагчид буцаан өгсөн;
- 4.3. Барьцаалуулагч гэрээний үүргээ зохих ёсоор биелүүлсэн,

## ГЭРЭЭ БАЙГУУЛСАН :

БАРЬЦААЛАГЧ :

Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч:

Нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(нэр) (гарын үсэг)

БАРЬЦААЛУУЛАГЧ :

Нэр \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(нэр) (гарын үсэг)

Регистрийн № \_\_\_\_\_ /

Хаяг \_\_\_\_\_

Утасны дугаар \_\_\_\_\_

Гадаадын иргэн, харьятын асуудал эрхлэх  
газрын даргын 2012 оны 11 дугаар  
тушаалын хоёрдугаар хавсралт

**МӨНГӨН ХӨРӨНГИЙГ БАРЬЦААЛСАН БОЛОН  
БУЦААН ОЛГОСОН, ШИЛЖҮҮЛСЭН ТУХАЙ БАРИМТ**

20....оны....сарын.....өдөр

(баримт үйлдсэн газрын нэр)

1. Мөнгөн хөрөнгийн барьцаа гаргасан: \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_  
хороо /баг/-ны \_\_\_\_\_ хот /аймаг/-ын \_\_\_\_\_ дүүрэг /сум/-ийн  
суугч, \_\_\_\_\_ байр, хашааны \_\_\_\_\_ тоотод оршин  
ажилтай, утасны дугаар \_\_\_\_\_

Иргэний үнэмлэхний дугаар \_\_\_\_\_  
Регистрийн дугаар \_\_\_\_\_  
Паспортын дугаар \_\_\_\_\_

БАРЬЦААЛУУЛАГЧ: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(нэр) (гарын үсэг)

2. Мөнгөн хөрөнгийн барьцаа гаргасан \_\_\_\_\_ хот/аймаг/-ын  
/дүүрэг/сум/-т байрлах \_\_\_\_\_ ХК, ХХК, ГХОК,  
(аль нь болохыг доогуур зурах)  
хөхрөлөл, хоршоо, сан. Утасны дугаар \_\_\_\_\_ факсын дугаар \_\_\_\_\_, И-  
мэйл хаяг \_\_\_\_\_ @ \_\_\_\_\_

Компаний улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар \_\_\_\_\_  
Эрхэлдэг үйл ажиллагаа \_\_\_\_\_

БАРЬЦААЛУУЛАГЧ: \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(нэр) (гарын үсэг)

3. Барьцаанд өгсөн мөнгөн хөрөнгө:

Төгрөг / \_\_\_\_\_ /  
(тоогоор)(үнийн дүнг үсгээр бичих)

4. Хамт байлцсан: \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_  
Хаяг \_\_\_\_\_  
Гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_

5. Хамт байлцсан: \_\_\_\_\_ овогтой \_\_\_\_\_  
Хаяг \_\_\_\_\_  
Гарын үсэг \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /

6. Барьцааг хүлээн авсан:  
Гадаадын иргэний хяналтын улсын байцаагч: / \_\_\_\_\_ /  
(нэр) (гарын үсэг)  
/хэлтэс, алба/-ны даргын баталгаажуулсан \_\_\_\_\_ дугаар  
(доогуур зурах)

санхүүгийн баримтыг үндэслэн 20...оны ... сарын ..... өдөр барьцааны мөнгөн хөрөнгийг буцаан олгов.

Барьцааны мөнгөн хөрөнгийг хүлээн авсан:

(нэр)(гарын үсэг)

Барьцааг буцаан олгосон /шилжүүлсэн/:

Хяналтын улсын байцаагч \_\_\_\_\_ / \_\_\_\_\_ /  
(нэр)(гарын үсэг)